

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболов

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны 82 дугаар захирамжаар төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатараар ахлуулан 21 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Улсын Их Хурлын бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн бусад Байнгын хороо, төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэгүй байх, Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3, 29.4-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан болно.

Төсвийн ажлын хэсгээс Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэхдээ мөн хэмжээгээр бууруулах зарчмыг

баримтлан дараах саналуудыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.Үүнд:

1.Байнгын хороодын хуралдаанаар бусад Байнгын хороодын дэмжсэн саналуудаас санхүүжих дунд өөрчлөлт орохгүй, Улсын Их Хурлын гишүүд орон нутагт 2022 оны төсвийн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх; санхүүжих дунд өөрчлөлт орохгүйгээр төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадалд өөрчлөлт оруулах; магадлалын дүгнэлт хийгдсэн, төсөвт өртөг нэмэгдүүлэх саналуудыг ажлын хэсгээс дэмжих нь зүйтэй гэж үзлээ.


2.Байнгын хороонд болон ажлын хэсэгт ирүүлсэн Улсын Их Хурлын зарим гишүүд, төрийн байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн санал нэг бурийг судлан үзээд эдийн засаг, нийгмийн үр ашгийг харгалзан салбарын бодлоготой уялдсан 2022 оны төсвийн жилээс эхлэн зайлшгүй тусгах шаардлагатай урсгал болон хөрөнгийн зардлыг төсвийн төсөлд эх үүсвэр олж тусгахаар санал бэлтгэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР